



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 01/42

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2022 оны 02-р тогтоол (Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.6.16 дэх заалт, сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны А/19 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Байгалийн нөөцийг хамгаалах зохистой ашиглах талаарх нутгийн иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагчдыг үр дүнгээр урамшуулах, идэвх санаачилгатай ажиллаж эргүүл хяналтын ажлыг тогтмол гүйцэтгэж буй идэвхтэн байгаль хамгаалагчдад шатахууны урамшуулал 221.600 (Хоёр зуун хорин нэг зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг байгалийн нөөц ашигласан орлогоос зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай


4. Шатахууны урамшуулал олгох идэвхтэн байгаль хамгаалагчдыг хавсралтаар баталсугай

ДАРГА



Ц. БАТЧУЛУУН

Сумын Засаг даргын 20 15 оны 08 дугаар
сарын 08 -ны өдрийн 01/16 тоот
захирамжийн I хавсралт



**БНХМ-ийн НӨХӨРЛӨЛҮҮДИЙН ШАТАХУУНЫ УРАМШУУЛАЛ АВАХ ИДЭВХТЭН
БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН НЭРС**

№	ОВОГ НЭР	НӨХӨРЛӨЛИЙН НЭР	ШАТАХУУНЫ ХЭМЖЭЭ /Л/	НЭГ БҮРИЙН ҮНЭ	НИЙТ ҮНЭ
1	Ж.МӨНХБОЛД	ЖАРГАЛАНТ	20	2770	55400
2	Н.ДАМДИНПУНЦАГ	ХАР-ОВООТ	20	2770	55400
3	Б.ОЮУНБААТАР	ДУХ	20	2770	55400
4	Ш.УУГАНБААТАР	ДУХ	20	2770	55400
НИЙТ ДҮН					221600